



**“БҮГД НАЙРАМДАХ УЗБЕКИСТАН УЛСЫН НИЙСЛЭЛ
ТАШКЕНТ ХОТОД МОНГОЛ УЛСЫН ЭЛЧИН САЙДЫН ЯАМ
НЭЭН АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

1. Тогтоолын төсөл боловсруулах болсон эрх зүйн үндэслэл, практик шаардлага:

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.5.5.-т “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцааг өргөжүүлэн, эдийн засгийн хамтын ажиллагааг бэхжүүлж, бусад улстай харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллана”, 4.5.8.-т “Улс төр, эдийн засгийн харилцааны түвшин, ач холбогдол, тухайн улсад оршин суугаа монгол иргэд болон харилцан зорчиж байгаа иргэдийн тоо зэргийг харгалзан Дипломат төлөөлөгчийн газруудын байршил, бүтэц, орон тоог оновчтой болгоно” гэж тус тус заасны дагуу Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулах дараах хууль зүйн болон практик шаардлага байна.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн шийдвэрийн дагуу 1977 онд Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотноо Ерөнхий консулын газар нээн 1994 он хүртэл ажиллуулж байсан болно. Манай улс Зөвлөлт Холбоот Улс задарсны дараа хоёр талын уламжлалт найрсаг харилцаа, Бүгд Найрамдах Узбекистан Улсын Төв Азийн бүс нутагт дахь нөлөөг харгалзан 1992 онд дипломат харилцаа тогтоосон.

Төв Азийн бүс нутгийн томоохонд зах зээлд тооцогдох 35 сая гаруй хүн амтай Узбекистан нь хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн хөгжлөөр бүс нутагтаа тэргүүлдэг тул Монгол Улсын хүнсний аюулгүй байдлыг хангах зорилтод нийцсэн эрүүл хүнсний бүтээгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх чиглэлээр хамтран ажиллах экспортлох, манай үндэсний үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг тухайн бүс нутагт таниулах, эдийн засгийн харилцааг өргөжүүлж худалдааны эргэлтийг

нэмэгдүүлэх, мах болон махан бүтээгдэхүүний экспортын чиглэлээр хамтран ажиллах өргөн боломж бүхий улс юм.

Хоёр талын худалдааны эргэлт сүүлийн жилүүдэд аажмаар өсөн 2022 онд 10.4 сая ам.долларт хүрсэн бөгөөд хоёр улсын Худалдаа, аж үйлдвэрийн танхимууд 2022 онд Ташкент хотод Монгол, Узбекистаны бизнес уулзалтыг хамтран зохион байгуулах зэргээр хамтын ажиллагаагаа өргөжүүлж байна.

Түүнчлэн, Бүгд Найрамдах Узбекистан Улс улс нь бие даасан гадаад бодлого явуулахыг эрхэмлэдэг, тухайн бүс нутагтаа нэлөө бүхий улс бөгөөд өнөөдрийн байдлаар тус улсад 66 дипломат болон олон улсын байгууллагын төлөөлөгчийн газар ажиллаж байна.

Тус улс сүүлийн жилүүдэд бүхий л салбарыг хамарсан өргөн хүрээтэй шинэчлэлийг өрнүүлж байгаа бөгөөд гадаад бодлогын хүрээнд 2020 онд Евроазийн эдийн засгийн холбоонд ажиглагч статустай болж, Дэлхийн худалдааны байгууллагад элсэх хүсэлтээ илэрхийлсэн байна.

Монгол Улсаас төв Азид чиглэсэн гадаад бодлогыг идэвхжүүлэх, гадаад худалдааг төрөлжүүлэх бодлогын хүрээнд хоёр улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх зорилгоор Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулах Засгийн газрын саналыг зөвшилцөхөөр 2023 оны 9 дүгээр сарын 06-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар уг саналыг зөвшилцөн дэмжсэн тул асуудлыг айлын талд дипломат шугамаар тавьж, зөвшөөрсөн хариуг авсан болно.

2.Тогтоолын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ:

Тогтоолын төсөл нь нэг заалттай байх бөгөөд үүнд, Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулахаар тусгана.

3.Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ:

Тогтоолын төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засаг, хууль зүйн аливаа сөрөг үр дагавар үүсэхгүй бөгөөд хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх ач холбогдолтой.

Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдын яам нь Дипломат харилцааны тухай Венийн конвенц болон дотоодын хууль тогтоомжид заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажиллана.

Түүнчлэн, Элчин сайдын яам гурван орон тоотой ажиллах бөгөөд холбогдох зардал 2024 оны төсөвт туссан болно.

4. Төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн төсөл:

Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох бусад хууль тогтоомжид нийцэх бөгөөд төсөлтэй уялдуулан бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хууль шинээр боловсруулах, хүчингүй болгох шаардлагагүй болно.

- - - o O o - - -